



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 15

Мандалговь

Б.Ганчимэгийг Луус сумын Засаг даргын
Тамгын газрын даргын албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Луус сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Баатарын Ганчимэг 82.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Ганчимэгийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Луус сумын Засаг даргын Тамгын газрын даргын
албан тушаалд нэр дэвшүүлсэн Б.Ганчимэгийн тухай
дүгнэлт**

1. Б.Ганчимэг нь 1982 онд Дундговь аймгийн Луус суманд төрсөн. 40 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2002-2006 онд Сутай хууль эрх зүйн дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2007-2021 онд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст бичиг хэргийн эрхлэгч, эд хөрөнгийн улсын бүртгэгч, эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч, хяналтын улсын байцаагч, 2021 оноос Луус сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.
4. Б.Ганчимэгийн төрийн албаны туршлага болон тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Луус сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ